



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ “ХАРГУЙ” ТӨХК-ИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн 2024 онд зорилтот түвшинд тусгагдсан дагуу Автомашины сэлбэг хэрэгсэл нийлүүлэгч сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны даргаар: Г.Төмөрбаатар /Ерөнхий инженер/
Нарийн бичгийн даргаар: И.Баяртуяа /Худалдан авалтын мэргэжилтэн/
Гишүүд: Г.Сайнбаяр /Дотоод хяналтын ажилтан/
Д.Оюун /Хөндлөнгийн гишүүн/
Д.Ганзориг /Хөндлөнгийн гишүүн/

2. Худалдан авах ажиллагааны тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хариуцлагатай ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Л.БАТ-ОКТЯБРЬ

